



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/54

Мандалговь

Гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн босго үнэ шинэчлэн батлах тухай 124 дүгээр тогтоол, сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх 3 ширхэг гүний худаг гаргах” ажлын гүйцэтгэгчээр “Эхний эхэн” ХХК-ийг сонгон 74,100,000 (далан дөрвөн сая нэг зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Гэрээнд заагдсаны дагуу чанарын шаардлага хангасан гүн өрмийн худаг гарган хүлээлгэн өгөхийг “Эхний эхэн” ХХК-ний захирал (О.Хүүхэнбаатар)-д даалгасугай.

3. Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ